



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.4.1 дэх заалт, тус газрын албан хаагчдын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. Тус газрын Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Ажлын хэсгийн дарга:	Ш.Цэрэндулам	Захиргааны хэлтсийн дарга
Гишүүд:	Д.Уламбаяр	Улсын сүлжээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Г.Амгалан	Улсын сүлжээний газрын Нислэг, хөдөө аж ахуйн цаг уурын улсын сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн
	Э.Дариймаа	Урьдчилан мэдээлэх газрын Орон нутгийн урьдчилан мэдээлэх үйлчилгээ хариуцсан ерөнхий инженер
Нарийн бичгийн дарга:	Т.Болор-Эрдэнэ	Захиргааны хэлтсийн Эрх зүй, гэрээ хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Ёс зүйн дэд хорооны ажиллах төлөвлөгөөг боловсруулж батлуулах, дүрэм, журмыг хэрэгжүүлэх ажлыг тус газарт зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Ёс зүйн дэд хорооны дарга (Ш.Цэрэндулам)-д даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан агентлагийн даргын "Ёс зүйн хороог шинэчлэн байгуулах тухай" 2024 оны А/08 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА